




**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ
2024 ОНЫ СУРГАЛТЫН ТАЙЛАН**



Д/д	Сургалтын нэр	Хамрагдсан албан хаагчийн тоо	Биелэлт
Ажлын байран дахь чадавхжуулах сургалт /4 цагаас дээш/			
1	Худалдан авах ажиллагааны АЗ сургалт	Суралцсан албан хаагчийн тоо -13 АЗ гэрчилгээтэй албан хаагчдын тоо - 7	Худалдан авах ажиллагааны А-3 гэрчилгээ олгох 3 өдрийн сургалтад 13 албан хаагч суралцан 7 албан хаагч тэнцэн гэрчилгээ авсан. 6 албан хаагч дахин шалгалт өгнө.
2	Байгууллагын архивын баримтын цахимжуулалт, тоо бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт	Сургалтын тоо- 2 Суралцсан албан хаагч - 2	<ul style="list-style-type: none"> ❖ АЕГ-аас 02 сарын 05-06-нд зохион байгуулсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүй” сургалтад Албан хэргийн хөтлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Одгэрэл хамрагдаж Г-24/50 дугаартай гэрчилгээ, ❖ Мөн АЕГ-аас 09 сарын 26-27-нд зохион байгуулсан “Архивын сан хөмрөгийн хадгалалт, тоо бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл” сургалтад архивч Т.Болор-Эрдэнэ хамрагдаж мэргэшүүлэх гэрчилгээ авсан. 
3	Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн шинжээч бэлтгэх, чадавхжуулах сургалт	Суралцсан албан хаагч - 5	Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн шинжээч бэлтгэх, чадавхжуулах 4 өдрийн сургалтад МИА-ны 5 албан хаагч хамрагдан суралцаж гэрчилгээ авсан.
4	Анхны тусламжийн сургалт	Суралцсан албан хаагч – 1	Анхны тусламжийн сургагч багш бэлтгэх 5 өдрийн сургалтад МИА-ны мэргэжилтэн Б.Базаррагчаа хамрагдсан.
5	Хүний эрх, жендэрийн сургалт	Сургалтын тоо -2 Суралцсан албан хаагч - 2	❖ 4 цагийн 5 модуль бүхий “Ахисан түвшний Жендэрийн дүн шинжилгээ” багц сургалтад ЗСУА-ны ахлах мэргэжилтэн Б.Байгалмаа, ЭМЭЗБСА-ны мэргэжилтэн Б.Отгончимэг нар хамрагдаж гэрчилгээ авсан.

			❖ “Хүний эрх” 1-р түвшний 12 цагийн цагийн цахим сургалтад ЭМЭЗБС-ны мэргэжилтэн Б.Отгончимэг суралцаж сертификат авсан.
6	Монгол бичгийн сургалт	Сургалтын түвшин - 2 Суралцсан албан хаагч – 46	 <p>“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн дагуу төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, бүх нийтээр монгол бичигт шилжих ажлын хүрээнд албан хаагчдынхаа монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2024 оны 10, 11 дүгээр сард нийт 20 цагийн монгол бичгийн анхан болон гүнзгий шатны сургалтыг Үндэсний бичгийн багш Н.Батбаяртай хамтран амжилттай зохион байгуулж, нийт 46 албан хаагч хамрагдлаа. /Анхан шат 26, Гүнзгий шат 20/</p>
7	“Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” сургалт	Суралцсан албан хаагч – 53	<p>Эрүүл мэндийн салбарын цахимжилт, цахим шилжилтийн талаар танилцуулах “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” сургалт 05.12-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан бөгөөд уг сургалтад тус төвийн 53 албан хаагч хамрагдсан. http://hdc.gov.mn/post/1335/</p> 
8	“Санхүүгийн журам болон eTools онлайн систем” сургалт	Суралцсан албан хаагч -4	<p>НҮБ-ийн Хүүхдийн сангаас 5 сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Санхүүгийн журам болон eTools онлайн систем” сургалтад ахлах нягтлан бодогч Б.Очир, Нягтлан бодогч С.Лхагвасүрэн, МТА-ны мэргэжилтэн Б.Солонго, ХНХА-ны мэргэжилтэн С.Дэнзэндулмаа нар хамрагдсан. НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн тайлагналтын талаар мэдээлэлтэй боллоо.</p>
9	Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд зориулсан цахим чадавхийг бэхжүүлэх сургалт	Сургалтын тоо- 3 Суралцсан албан хаагч – 4	<p>❖ МТА-ны Кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Гантулга MITRE байгууллагаас 2024 оны 4 сарын 02-04-ны өдрүүдэд зохион байгуулсан “Цахим чадавхийг бэхжүүлэх нь” сургалтад суралцаж, гэрчилгээ авлаа.</p>

			<ul style="list-style-type: none"> ❖ МТА-ны мэргэжилтэн А.Биндэръяа, Б.Алтангэрэл ҮСХ-ноос зохион байгуулсан “Стата программын анхан шатны сургалт”-д хамрагдаж, гэрчилгээ авсан. Сургалтад хамрагдсанаар тухайн программыг ашиглан статистик мэдээлэл болон судалгаа нэгтгэх тайлан гаргах чадамжтай болсон. ❖ МТА-ны мэргэжилтэн М.Цолмон Интерактив ХХК-аас зохион байгуулсан “Enterprise Metaverse Studio платформын хөгжүүлэгчийн сургалт”-д хамрагдаж гэрчилгээ авсан.
10	Статистик, мэдээллийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт	Сургалтын тоо -2 Суралцсан албан хаагч – 2	<ul style="list-style-type: none"> ❖ МТА-ны мэргэжилтэн Х.Дэлгэрмаа ҮСХ-ноос зохион байгуулсан “Ази номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд статистикийн чанарыг сайжруулах нь” сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. ❖ МТА-ны мэргэжилтэн Б.Алтангэрэл нь ҮСХ-ноос зохион байгуулсан 3 өдрийн “Эксел программын хэрэглээний анхан болон дунд түвшний хөтөлбөр”-т суралцаж сертификат авсан. 
11	“Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн кибер аюулгүй байдал”	Суралцсан албан хаагч – 1	Хэвлэлийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн кибер аюулгүй байдал” сургалтад ЗСУА-ны ахлах мэргэжилтэн Б.Нямсүрэн хамрагдаж гэрчилгээ авсан. Уг сургалтаар Австрали улсын Кибер аюулгүй байдлын сургагч багш хүрэлцэн ирж төрийн байгууллагууд цахим халдлагаас хэрхэн сэргийлэх, ялангуяа цахим сүлжээгээ хэрхэн хамгаалах талаар мэдээлэл зөвлөгөө өглөө.
Ажлын байран дахь чадавхжуулах нийт 11 чиглэлийн 16 сургалтад давхардсан тоогоор 113 албан хаагч хамрагдсан.			
Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх сургалт			
12	Тархвар зүйч	Суралцсан албан хаагч – 1	Тархвар зүйн сургалтад МТА-ны мэргэжилтэн Г.Ган-Эрдэнэ суралцаж байна.
13	Биостатистикч	Суралцсан албан хаагч – 2	МТА-ны мэргэжилтэн Б.Алтангэрэл, Ж.Ундрал нар АШУУИС-ийн Биостатистик судлал төрөлжсөн мэргэшлийн сургалтад элсэн суралцаж байна.



14	Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт	Суралцсан албан хаагч – 1	Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт сургалтад ЭЭЭШСҮАЗА-ны ахлах мэргэжилтэн Б.Алтантулга суралцаж гэрчилгээ авсан.	
15	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал	Суралцсан албан хаагч – 1	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сургалтад ЭМЭЗБСА-ны дарга С.Мөнхсүх суралцаж гэрчилгээ авсан.	
16	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	Суралцсан албан хаагч – 1	Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт МТА-ны мэргэжилтэн Б.Долгормаа суралцаж төгссөн.	
17	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт	Суралцсан албан хаагч – 1	Удирдлагын академийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад ХНХА-ны дарга Б.Отгончимэг суралцаж байна.	
18	Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалт	Суралцсан албан хаагч -1	Төрийн удирдлагын мэргэшлийн сургалтыг МИА-ны мэргэжилтэн Б.Мөнхбат дүүргэж, дипломоо авсан.	
19	Боловсролын зэргээ дээшлүүлэх (докторантур) сургалт	Суралцсан албан хаагч – 3	Эрүүл мэндийн бодлого, удирдлага чиглэлээр АШУҮИС-ийн докторантурт Ахлах нягтлан бодогч Б.Очир, Нийгмийн эрүүл мэнд судлалаар докторантурт ЭМЭЗБСА-ны ахлах мэргэжилтэн Ц.Болормаа, төрийн удирдлагын докторантурт ХШҮДАА-ны ахлах мэргэжилтэн Б.Батнаран суралцаж байна.	
20	Боловсролын зэргээ дээшлүүлэх (магистрантур) сургалт	Суралцсан албан хаагч – 2	<ul style="list-style-type: none"> ❖ ЭМЭЗБСА-ны ахлах мэргэжилтэн Ч.Мичидмаа БНСУ-ын Йонсей их сургуульд Эрүүл мэндийн бодлого, санхүүжилт чиглэлээр магистрийн хөтөлбөрөө дуусган ажилдаа орсон. ❖ МТА-ны мэргэжилтэн Б.Солонго ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэн БНСУ-ын Йонсей их сургуульд магистр суралцахаар явсан. 	
Гадаад сургалт				



21	Гадаад сургалт	Сургалтын тоо -17 Суралцсан албан хаагч – 31	<p>Албан хаагчдыг чиг үүргийн дагуу гадаад сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж 16 гадаад сургалтад 29 буюу нийт албан хаагчдын 36 хувь нь хамрагдан суралцсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ❖ БНХАУ-ын Чанша хотод зохион байгуулагдсан “Мансууруулах бодис хэрэглэх, донтох зан үйлээс үүдэлтэй эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх нь” сургалтад ХНХА-ны дарга Б.Отгончимэг, ❖ БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан удирдах ажилтны сургалтад захирал болон ХНХА-ны мэргэжилтэн Б.Мөнхчимэг, ❖ Сингапур улсад зохион байгуулагдсан “Өвчтөний аюулгүй байдлын талаар улс хоорондын чадавхийг бэхжүүлэх нь” сургалтад МИА-ны ахлах мэргэжилтэн Л.Бор, ❖ БНХАУ-ын Хөх хотноо зохион байгуулагдсан “Орон нутгийн багийн эмч нарыг чадавхжуулах богино хугацааны сургалт”-д Д.Дондогмаа, Б.Мөнгөнзул, Л.Баянжаргал, Г.Раднаа, ❖ БНХАУ-ын Хөх хотноо зохион байгуулагдах “Сумын эрүүл мэндийн төвийн сувилагч нарыг чадавхжуулах богино хугацааны сургалт”-д Я.Бадамсүрэн, Н.Бүрэнжаргал, П.Мидриймаа, Б.Нямсүрэн, ❖ БНХАУ-ын Хөх хотноо зохион байгуулагдсан “Монгол анагаах ухааны мэргэжилтэнг чадавхжуулах олон улсын эмнэл зүйн сургалт”-д З.Наранбаатар, ❖ Япон улсын Токио хотод 2024 оны 5 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Ерөнхий мэргэшлийн эмчийн сургалт”-д С.Лхагвадорж, ❖ БНСУ-ын Сөүл хотод болох “Виталлинк академи түвшин-2” сургалтад Г.Батцэцэг, Б.Алтантулга, ❖ Малайз Улсын Куала Лумпур хотноо зохион байгуулагдах “Эрүүл мэндийн тэгш байдлын хяналт” сургалтад Б.Солонго, ❖ БНХАУ-ын ӨМӨЗО-ны Жинин хотноо зохион байгуулагдах “Анхны тусламжийн сургагч багш бэлтгэх сургалт”-д С.Даваажаргал, ❖ БНСУ-ын Сөүл хотод болсон БНСУ-ын нефрологийн нийгэмлэгийн 44 дэх уулзалтад Г.Батцэцэг, ❖ Малайз Улсын Куала Лумпур хотноо зохион байгуулагдсан “Ази, Номхон далайн орнуудын эрүүл мэндийн үндэсний тооцооны мэргэжилтнүүдэд зориулсан сургалт”-д ЭМЭЗБСА-ны ахлах мэргэжилтэн Ч.Мичидмаа, Ц.Болормаа, ❖ Япон улсад зохион байгуулагдсан “Боловсролын байгууллагын эрүүл мэндийн багш, арга зүйч бэлтгэх туршлага судлах сургалт”-д ХНХА-ны мэргэжилтэн Б.Оюунсайхан,
----	----------------	---	---



			<ul style="list-style-type: none"> ❖ ЭМЭЗБСА-ны мэргэжилтэн Б.Норолхоосүрэн БНСУ-д “Хувь хүний хөгжлийн сургалт” -д, ❖ БНАЛАУ-ын Вьентян хотноо зохион байгуулагдсан “Номхон далайн баруун хэсэгт ирээдүйн эрүүл мэндийн ажиллах хүчийг хэрхэн бүрдүүлэх нь” сургалтад ХНХА-ны дарга Б.Отгончимэг, ❖ БНХАУ-ын Бээжийн хотноо зохион байгуулагдсан “Бүс ба зам санаачлага” ОУ-ын анагаах ухааны эрдэмтдийн хамтын ажиллагааны семинар”-т 6 албан хаагч хамрагдсан. ❖ Малайз Улсын Куала Лумпур хотноо зохион байгуулагдах “Link plus программ хангамжийг ашиглан өвчний тандалтын тогтолцооны чанарыг сайжруулах нь” сургалтад МТА-ны Г.Ган-Эрдэнэ, Б.Алтангэрэл нар суралцсан. <ul style="list-style-type: none"> ❖ Зохион байгуулсан сургалт: 17 ❖ Хамрагдсан албан хаагчийн тоо: 31
Бусад сургалт			
22	Шинэ албан хаагчдад зориулсан чиглүүлэх сургалт	Суралцсан албан хаагч – 8	<div style="display: flex; justify-content: space-between;"> <div style="width: 45%;">  </div> <div style="width: 50%;"> <p>Шинээр ажилд орсон албан хаагчдад Чиглүүлэх сургалтыг 2 удаа /2024.06.04, 2024.08.21/ зохион байгуулж, Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Нууцын журам, ERP системд ажиллах заавар, Мэдээллийн аюулгүй байдлын журмыг танилцуулж мэдээллийг олгов. Шинээр ажилд орсон 8 албан хаагч хамрагдсан. Уг арга хэмжээний хүрээнд Шинэ ажилтныг чиглүүлэх процессын дараалал бүхий А5 хэмжээтэй 4 хуудас /8 нүүр/ гарын авлагыг боловсруулж, гаргасан. Гарын авлагад:</p> <ul style="list-style-type: none"> - байгууллагын мэдээлэл, танилцуулга - чиглүүлэг дараалал - дэмжлэг, тусламж - уншиж судлах хууль, журам багтсан. <p>Мөн шинэ ажилтанд зориулсан танилцуулах, чиглүүлэх цаасан материал бүхий хавтас бэлтгэн шинэ ажилтанд уншуулж танилцуулж байна. 2024 онд шинээр ажилд орсон 19 албан хаагчдад гарын авлагыг цахимаар хүргүүлж, мэдээлэл өгсөн.</p> </div> </div> <div style="text-align: right; margin-top: 20px;">  </div>



23	Сэтгэлзүйн сургалт оношилгоо,	Суралцсан хаагч - 42 албан	<p>2024.04.12-ны өдөр СЭМҮТ-ийн эмч магистр, Л.Эрдэнэсүвдэг урьж, ажлын байрны стресс тайлах арга сэдвээр бүлгийн ярилцлага, багийн ажлыг зохион байгуулж, 42 албан хаагч хамрагдав. http://hdc.gov.mn/post/1306/</p> <p>Уг арга хэмжээний хүрээнд сэтгэлзүйн оношилгоо хийх аргыг танилцуулан, уг аргаараа албан хаагчид өөрсөдийгөө болон нэг нэгнээ оношилон, ажлын байрны стресс, бухимдлаа тайлах аргазүйд суралцлаа.</p>
24	“Хавар цагийн идээ ундаа, явдал мөр”	Суралцсан хаагч – 46 албан	<p>УАУТХ-тэй хамтран 2 сарын 20-ны өдөр зохион байгуулсан уг сургалтаар Уламжлалт анагаах ухаан онол болон хавар цагт уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хэрхэн хамгаалах талаарх мэдээлэл өгч, сонирхсон асуултад хариуллаа. https://hdc.gov.mn/post/1253/</p> 
25	Гадаад бодлого, гадаад харилцааны асуудал, олон улсын гэрээ, эрх зүйн талаар мэдээлэл, дипломат албаны нарийн дэг жаяг	Суралцсан хаагч - 44 албан	<p>ГХЯ-ны Дипломат ёслолын газрын зөвлөхтэй хамтран Ёслолын сургалтыг 1 сарын 19-ний өдөр зохион байгуулж, 44 албан хаагч хамрагдсан. https://hdc.gov.mn/post/1221/</p>

			<p>Сургалтаар гадаад болон дотоодын ёслолын арга хэмжээ зохион байгуулах хэм, хэмжээ, ёсзүйг танилцуулан, хүлээн авах, гэрээ байгуулах, санамж бичиг зурах, цайллага хийх зэрэг ёслолын арга хэмжээг хэрхэн зохион байгуулах, биеэ авч явах явах талаар мэдээлэл хийж, ГХЯ-наас зохион байгуулсан араг хэмжээнүүдийн жишээгээр сайн болон муу туршлагаас хуваалцлаа.</p> <p>Мөн гадаад бодлого, гадаад харицааны асуудлууын талаар мэдээлэл өглөө.</p>
26	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, тайлагналд анхаарах асуудал” сургалт	Суралцсан албан хаагч – 3	<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, тайлагналд анхаарах асуудал” сургалтад Дотоод ажлын зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Тунгалаг, Хангамж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Мөнгөнзул, Нягтлан бодогч П.Сарантуяа нар хамрагдлаа.</p> <p>Сургалтаар өмч хөрөнгийн бүртгэл ашиглалт, тайлагналтын үйл ажиллагаанд хэрэгжиж буй хууль эрхзүйн талаар болон анхаарах асуудлаар Төрийн өмчийн хорооны холбогдох мэргэжилтнүүд мэдээлэл өглөө.</p>
27	“Төрийн албаны цалингийн нэгдсэн систем” сургалт	Суралцсан албан хаагч – 1	<p>Төрийн албаны цалингийн нэгдсэн систем, Төрийн албаны хүний нөөц системийн сургалтад Нягтлан бодогч П.Саранцэцэг хамрагдлаа.</p> <p>Сургалтаар Цалингийн нэгдсэн системд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтийн талаар мэдээлэл өглөө.</p>

28	Ажил эрхлэлт, хөдөлмөрийн хүрээний дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сургалт	Суралцсан албан хаагч – 28	Тус төвөөс Хүний эрхийн үндэсний комисст хүсэлт тавьж албан хаагчдадаа 09 сарын 20-ны өдөр “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар хүний эрхийн үндсэн ойлголт, суурь зарчим, хүний эрхийн хязгаарлалт, хүний эрхийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрхийн баталгаа, зөрчил, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, хандлага олголоо. Ингэснээр албан хаагчид хүний эрхийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм. http://hdc.gov.mn/post/1477/	
29	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох тухай /“Эрүүл мэндийн хөгжил” ахмадын холбоотой хамтран зохион байгуулна./	Суралцсан албан хаагч - 37	Тус төвөөс гавьяаны амралтад гарсан ахмадуудын үүсгэн байгуулсан “Эрүүл мэндийн хөгжил” ахмадын холбоотой хамтран жил бүр арга хэмжээ зохион байгуулдаг өгөөд энэн жилийн хувьд эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох зорилтын хүрээнд зохион байгуулж буй 3 дахь жилийн ажил болгох “Та дурласан уу” сургалтыг ахмад мэргэжилтэн Ч.Батнасан орж 37 албан хаагч хамрагдлаа. https://www.hdc.gov.mn/post/1545/	

30	Жендэрийн тухай ойлголт, тэнцүү ба тэгш байдал	Суралцсан албан хаагч – 34	 <p>Төвийн ЗСҮА-ны Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Жендэрийн сургагч багш Б.Байгалмаа “Жендэрийн тэнцүү ба тэгш байдал” сургалтыг 12 сарын 5-ны өдөр зохион байгуулж 34 албан хаагч хамрагдав.</p> <p>Сургалтаар Жендэрийн үйл ажиллагааг таниулах 16 хоногийн аяны талаар болон Жендэрийн талаарх ойлголт өгч, дадлага ажиллалаа.</p>
31	“Дулаахан” сургалт	Суралцсан албан хаагч – 38	<p>МЭХ-той хамтран 3 сарын 01-ний өдөр зохион байгуулсан “Дулаахан” сургалтад 38 албан хаагч хамрагдсан.</p> <p>Тус төвийн албан хаагчдын ээлжит мэдээллийн цагаар Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Б.Оюунгэрэлийг урьж Монголын эмэгтэйчүүдийн холбооны түүх, үйл ажиллагааны талаар болон түүний “Дулаахан...” хэмээх илтгэлийг сонсож, харилцан ярилцлаа. Уг уулзалтад мөн Монголын эмэгтэйчүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Хан-Уул салбар зөвлөлийн тэргүүн Т.Уранчимэг, Удирдах зөвлөлийн гишүүн Дорноговь аймгийн салбар зөвлөлийн тэргүүн Сэмжидтуяа нар хамтран оролцлоо. Энэ үеэр тус холбооноос хэрэгжүүлж буй арга хэмжээ болон "Нандин" төслийнхөө талаар дэлгэрэнгүй танилцууллаа. https://hdc.gov.mn/post/1268/</p> 
32	Нийгмийн сүлжээнд мэдээлэл түгээх оновчлол, эргэх холбоо Хэвлэлийн мэдээ боловсруулах аргачлал, тавигдах шаардлага	Суралцсан албан хаагч – 35	<p>Сургалтыг 12 сарын 11-ний өдөр зохион байгуулж 35 албан хаагч хамрагдлаа.</p> <p>Сургалтаар Нийгмийн сүлжээг ашиглан мэдээлэл, сурталчилгаа түгээх, хэвлэлийн мэдээ бичих, Нийгмийн сүлжээний алигритм болон нийгмийн сүлжээ хэрхэн хиймэл оюун ухааныг ашиглаж байгаа талаар мэдээлэл өглөө.</p> <p>Сургалтыг Эрдэнэс монгол ХХК-ны хэвлэлийн албаны дарга, Хэвлэлийн хүрээлэнгийн сургагч багш А.Адьяасүрэн заалаа.</p>

33	“Үер, усны аюул, осол гэмтэл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний талаарх” цахим сургалт	Суралцсан албан хаагч – 10		ЭМЯ-наас зохион байгуулсан “Үер, усны аюул, осол гэмтэл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний талаарх” цахим сургалтад 5 албаны 10 албан хаагч хамрагдаж гамшгийн үеийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад суралцан, бэлтгэл бэлэн байдлыг хангалаа.
34	“Албан хэрэг хөтлөлтөд Монгол бичиг ашиглах стандарт”	Суралцсан албан хаагч – 39		2025 оноос албан хэрэг хөтөлөлтөд хос бичиг ашиглахтай холбоотойгоор АЕГ-т хүсэтл тавин Архивын ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ц.Золжаргал “Албан хэрэг хөтлөлтөд Монгол бичиг ашиглах стандарт” сэдэвт сургалтыг зохион байгуулан 39 албан хаагч хамрагдлаа.
35	“Кибер аюулгүй байдал” сургалт	Суралцсан албан хаагч – 19	<p>ТЕГ-ын Мэдээллийн аюулгүй байдлын газрын ажилтан Г.Ариунсанаа МТА-ны мэргэжилтнүүдэд “Кибер аюулгүй байдал” сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 19 албан хаагч хамрагдаж:</p> <ul style="list-style-type: none"> - Кибер аюулгүй байдлын тухай хууль, - Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам, - Хаалттай болон эмзэг мэдээлэл - Цахим аюулгүй байдал, хэрхэн хангаж ажиллах талаар мэдлэг мэдээлэл олголоо. 	
Хууль тогтоомжийг сурталчлан таниулах болон ёс зүйн сургалтууд				

38	“Байгууллагын соёл” сургалт	Суралцсан албан хаагч – 40	<p>“Төрийн байгууллагын соёл ба ёс зүй” сэдвээр сургалтыг 2024.09.24 -ний өдөр Удирдлагын академийн багш, доктор Н.Цолмонтуяа орж, 40 албан хаагч хамрагдсан Сургалтаар байгууллагын уур амьсгалд сайнаар нөлөөлөх хүчин зүйл, удирдлагын зөөлөн ур чадвар ба баг хамт олон аливаа зүйлд эзний сэтгэлээр хандах сэтгэл зэрэг байгууллагын соёлыг бий болгох үнэт зүйлийн талаар мэдлэг олгосон.</p>  <p>http://hdc.gov.mn/post/1484/.</p>
39	“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” сургалт	Суралцсан албан хаагч – 49	<p>“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай эрх зүйн ойлголт” сургалтыг Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор А.Алтанзулыг урьж зохион байгууллаа. Тус төв нь иргэний эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцан ажилладаг бөгөөд цахим шилжилтийн хүрээнд хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр албан хаагчдаа чадавхжуулж, мэдээлэл хариуцагчийн хувьд эрсдэлээс сэргийлэх хууль эрх зүйн мэдээллийг өглөө.</p>  <p>http://hdc.gov.mn/post/1501/</p>
40	“Төрийн албан хаагчийн ёс зүй, эрүүл мэндийн салбарын онцлог” сургалт	Суралцсан албан хаагч – 290	<p>“Төрийн албан хаагчийн ёс зүй, эрүүл мэндийн салбарын онцлог” сургалтыг 2024.05.07-ны өдөр Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор А.Алтанзулыг урьж зохион байгууллаа. УНТЭ дээр зохион байгуулагдсан уг сургалтад 280 резидент эмч, Хүний нөөцийн хөгжлийн албаны мэргэжилтнүүд хамрагдаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Эрүүл мэндийн салбарын ёс зүйн дүрмийн онцлог,</p>

			эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн талаар мэдлэг мэдээлэл олгосон.
41	“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтууд	Зохион байгуулсан сургалтын тоо -6 Хамрагдсан хүний тоо-312 /давхардсан тоогоор/	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төвийн албан хаагчид болон эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт 6 зохион байгууллаа.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Жил бүр зохион байгуулагддаг “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын элсэлт, төгсөлт”, “Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их дээд сургууль, коллеж төгссөн төгсөгчдөөс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох”, “Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох”, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын шалгалтын комиссын бүрэлдэхүүн”-д томилогдсон ЭМЯ-ны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбооны гишүүд болон бусад бүрэлдэхүүнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхийг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргах” тухай 5 удаагийн сургалтыг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтаар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, албан тушаалтанд тавигдах 12 төрлийн хориглолт, хязгаарлалт, нийтлэг ирдэг өргөдөл, гомдол, албан тушаалтнуудын гаргадаг зөрчил дутагдал, анхаарах асуудлын чиглэлээр мэдээлэл өгсөн. ❖ Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад элсэхээр бүртгүүлсэн шалгуулагчдад 2024 оны 09 сарын 13-ны өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” чиглэлээр сургалт, мэдээлэл, зөвлөгөө өглөө. Уг сургалтаар төвийн ХШҮДААлба нь АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх эрх зүйн зохицуулалт, хориглолт, хязгаарлалтаас гадна авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, өргөдөл гомдлоо хэрхэн хаана гаргах чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгсөн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ